



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар A/05

Онги

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Мааньт багийн нутаг "Алаг-ийн бууц" / N45.553205 E103.740661/ гэх газарт Бог малын мялзан өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдэн лабораторийн шинжилгээний хариу гарах хугацаанд тухайн газарт өвөлжиж байгаа айл өрхийн орчинд 2023 оны 01 сарын 16- наас хязгаарлалтын дэглэм тогтоосугай.
2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсээс гарах мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хориглосугай.
3. Тухайн багийн айл өрхүүдийн мал сүрэгт эмнэлзүйн үзлэг, ариутгал халдвартгүйтгэл, эмчилгээ хийж ажиллахыг "Онги таван эрдэнэ" мал эмнэлэг, үйлчилгээний нэгжийн малын эмч (Б.Цэнгэлмаа), тандалт хийж хариуг мэдэгдэн ажиллахыг мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч эмч (Г.Дэлгэрмаа ), Багийн засаг дарга (П.Энхсайхан) нарт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Ц.Саранчимэг )-т даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

С. АМАРСАНАА